



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД  
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2024.01.22 № 03

Г Ашигт малтмалын лицензийн талаар Г

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын 48 дугаар тогтоолд “ил тод, хариуцлагатай уул уурхай, эрдэс баялгийн салбарыг хөгжүүлж, түүнээс олох орлогыг ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн бие даасан хөгжлийг хангах олон тулгуурт бүтцийг бий болгох”, “эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэхдээ үндэсний аюулгүй байдлын баталгааг хангахыг чухалчилж, түүхий эдийн хавсарга, гадаад, дотоодын улс төр, бизнесийн ашиг сонирхлын сөргөлдөөний талбар болох байгаль орчныг доройтуулахаас сэргийлэх, орлогод тавих хяналтыг сайжруулна.” гэж заасан.

Иймд Улсын Их Хурлын гишүүн би Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Уrt хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д тусгасан зорилтуудын хэрэгжилт, цаашдын бодлого төлөвлөлтийн талаар мэдээлэл авах зорилгоор Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Уул уурхайн салбарын үйл ажиллагааг зохицуулж байгаа, ялангуяа ашигт малтмалын тухай хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын хэрэгжилт, хууль эрхзүйн орчинд тулгарч байгаа асуудал, боловсронгуй болгох чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай;
2. Уул уурхай, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгож эхэлснээс өнөөдрийг хүртэлх Улсын хэмжээнд нийт олгогдсон уул уурхай, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талаарх тоо баримт, дэлгэрэнгүй мэдээллийг он тус бүрээр;
3. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн шилжилт, хөдөлгөөний талаарх тоо баримт, дэлгэрэнгүй мэдээлэл он тус бүрээр;
4. Уул уурхай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа хувь хүн аж ахуйн нэгж, байгууллагын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл 2024 оны 1 дүгээр сарын байдлаар;
5. Уул уурхай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллага болон гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай компанийн талаарх мэдээлэл;


2024000007

6. Нөөцөд авсан талбайн талаарх мэдээлэл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай;
7. Стратегийн ордууд, түүнийг ашиглах бодлогын талаарх мэдээлэл;
8. Баялгийн менежментийг оновчтой болгох талаарх хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, бодлого төлөвлөлтийн талаар зэрэг болно.

Дээрх асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасан хугацаанд бичгээр ирүүлэх бөгөөд мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар танилцуулах болно.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Б. БАТТӨМӨР

2024000007